ҮР НӨЛӨӨНИЙ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Ерөнхий мэдээлэл

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний судалгааг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр Ойн түншлэлийн хүрээнд “Ирээдүйн Ой” (F4F) техник туслалцаагаар боловсруулав. Энэхүү судалгаа нь Ойн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр хийгдсэн судалгааны тайлан болно. Судалгааны тайланд дурдагдсан дүгнэлт нь Европын Холбооны байр суурийг илэрхийлэхгүй, зөвхөн судлаачийн байр суурь болно. Судалгааны мэдээлэл бэлтгэхэд ашигласан аргазүй, аргачлалын зохистой, үнэн зөв байдлыг судлаач хариуцна.

Ойн түншлэл нь Европын Холбооны Global Gateway - Тогтвортой санхүүжилтийн стратегийн хүрээнд хэрэгжиж буй тэргүүлэх хөтөлбөр бөгөөд түнш орнуудын хооронд ойн нөөц, ойн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахад чиглэсэн урт хугацааны хамтын ажиллагааны илэрхийлэл юм.

Хэрэгжүүлэгч байгууллага:

FUNDED BY THE EUROPEAN UNION

FORESTS FOR THE FUTURE FACILITY

particip

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 3
УДИРТГАЛ 4
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ 6
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСЭГ 7
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг 8
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг 9
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг 11
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг 11
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг 12
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ 13
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 14
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 17
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 24
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 27
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 29
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 32
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилгод хүрэх байдал: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал 8
Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал 9
Хүснэгт 3. Ойлгомжтой байдал: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал.....11
Хүснэгт 4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал.....11
Хүснэгт 5. Харилцан уялдаа: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал.....12
Хүснэгт 6. Шалгуур үзүүлэлт ба тохирох шалгах хэрэгсэл 13
Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт-Үнэлэх хэсэг-Тохирох шалгах хэрэгсэл.....13
Хүснэгт 8. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 24
Хүснэгт 9. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байдал 25
Хүснэгт 10. Улсын Их Хурлын бүрэн эрх /Нэмэгдсэн чиг үүрэг/.....29
Хүснэгт 11. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал 30

УДИРТГАЛ

Ойн тухай хууль нь анх 1995 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан. Улмаар 2007 болон 2012 онд Ойн тухай хуулийг шинэчлэн найруулсан бөгөөд өдгөө 14 дэх жилдээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Сүүлийн жилүүдэд Ойн тухай хуулийн үзэл баримтлалыг сайжруулах, асуудал яригдаж, 2022 онд 3 удаа, 2023 онд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Гэвч эдгээр нэмэлт, өөрчлөлт нь Ойн тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг цогцоор шийдвэрлэж чадаагүй байна.

Монгол Улсын "Ойн нөөц баялаг" нь байгаль орчны тэнцвэрт байдал, усны нөөц, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, биологийн олон янз байдлыг дэмжих зэрэг стратегийн чухал ач холбогдолтой хүрээлэн буй орчны судлагдахуун билээ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт заасан "Ногоон хөгжил" буюу зорилго 6-д "Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна." гэж заасан. Энэхүү зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.1.3-т "Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ." гэж, 6.2.3-т "Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна." гэж, 6.2.4-т "Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ." гэжээ.

Тэрбум мод" үндэсний хөтөлбөр нь ойн санг нэмэгдүүлэх тухай улсын хэмжээнд ногоон хөгжлийн бодлогыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Ногоон хөгжлийн бодлого, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд ойн салбарын эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Харин Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.5.3.3-т "Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон үндсэн ашиглалтын огтлолыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ" гэж, 3.5.3.4-т "Мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ" гэж тус тус заажээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 6.2.5-д "ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ." гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоол баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.4.1.4-т "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8.8 хувьд хүргэнэ" гэж, 3.4.1.5-д "Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, ойн хомсдол, дороитлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ" гэж тус тус заажээ.[1]

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 58 дугаар зарлигаар "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Дээрх эрх зүйн баримт бичгээс үзвэл, Ойн тухай хуулиар зохицуулагдаж буй харилцаа нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой харилцан уялдаж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг судалгаанд суурилж боловсруулах зорилгоор хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа хийж, тайлан болон бусад холбогдох эх сурвалж, судалгааны үр дүнг ашигласан байна. Дээр дурдсан бодлогын баримт бичиг болон судалгааны тайлангийн дүгнэлт, санал, зөвлөмжид тусгасан асуудлууд

[1] Ойн тухай хууль, Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан

нь Ойн тухай хуулийн төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага юм. Улмаар Ойн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төслийг хэлэлцэх, зөвлөлдөх ажиллагаа өрнөж байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу уг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Энэхүү судалгааны ажлын зорилго нь Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

Судалгааны арга зүй. Энэхүү судалгаанд баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, хууль зүйн техник, хууль тайлбарлах зэрэг судалгааны аргыг ашиглав. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ыг ашиглаж, үнэлгээ хийх ажиллагааг дараах үе шаттай зохион байгуулсан. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Судалгааны ажлын хүрсэн үр дүн. Ойн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж дүгнэн, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, практикт хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж бүхий тайлан боловсруулав.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Ойн тухай хууль 12 бүлэг, 59 зүйлтэй. Тус хуулийн хүрээнд Монгол Улсын ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх тогтвортой ашиглалтыг хангах, ойн экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалах, ойн нөөцийн эдийн засгийн үр өгөөжийг байгаль хамгаалалтай уялдуулах, орон нутгийн оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусган, зарим зохицуулалтын хувьд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулсан байна.

Монгол Улсад Ойн нөөц баялаг нь байгаль орчны тэнцвэрт байдал, усны нөөц, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, биологийн олон янз байдлыг дэмжих зэрэг стратегийн чухал ач холбогдолтой хүрээлэн буй орчны судлагдахуун билээ. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр нь ойн санг нэмэгдүүлэх тухай улсын хэмжээнд ногоон хөгжлийн бодлогыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн түүнчлэн ногоон хөгжлийн бодлого, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд ойн салбарын эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлагатай байна. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжид буй харилцааг илүү нарийвчлан зохицуулж, нэр томьёог илүү оновчилж, хууль хэрэглээнд нэг утгаар ойлгох ойлголтын хүрээг тодорхой болгосон ба ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрх зүйн үндсийг бэхжүүлэх, олон улсын жишигт нийцсэн тогтвортой ойн менежментийг бий болгох зорилготой.

Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"[2]-ын 2.2-т заасан үндсэн шалгуур үзүүлэлтээс дараах 5 төрлийн шалгуур үзүүлэлтээр уг төслийн үр нөлөөг тооцох нь зүйтэй гэж үзлээ.[3] Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал: Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэлнэ;
2. Практикт хэрэгжих боломж: Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлнэ;
3. Ойлгомжтой байдал: Хуулийн төслийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субьектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэх, хуулийн төсөл хэл зүй, найруулгын шаардлага хангахаар томьёологдсон эсэхийг үнэлнэ;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана;
5. Харилцан уялдаа: Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг үнэлнэ.

Дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, дараах нөхцөлийг тогтооно. Үүнд:

1. Хуулийн төслийн зохицуулалтууд нь Ойн тухай хуулийн "Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэсэн зорилтод нийцсэн эсэх, хуулийн зарчим, үзэл баримтлалд тулгуурласан эсэх, хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээнд нийцүүлэн

[2] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал

[3] Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоог тусгайлан хийх тул энэхүү судалгаанд "Зардал" гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

боловсруулсан эсэх, төрийн бодлого, тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгод хүрэх боломжтой эсэх;

2. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт ойлгомжтой эсэх, Ойн тухай хууль болон бусад хуульд нийцсэн эсэх, практикт үүссэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, хэрэгжих боломжтой байдлаар зохицуулсан эсэх;
3. Хуулийн төслийн дагуу шинээр үүрэг хүлээх байгууллагууд төслийг хүлээн зөвшөөрөх эсэх, тэдгээрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд нийцсэн эсэх.

Тус хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал, төсөлд тусгасан зорилгод хүрэхэд чиглэж, тухайн зорилгодоо хүрэх боломжтой эсэх, хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагыг хангах боломжтой эсэхэд анхаарч төслийн үр нөлөөг үнэлэх ажлыг гүйцэтгэв. Иймээс энэхүү судалгааны ажил нь хуулийн төсөлд үнэлгээ хийхээр сонгон авсан шалгуур үзүүлэлтээр хязгаарлагдана.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСЭГ

Энэ хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, хэсэг, заалтыг сонгоно.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах агуулга бүхий зүйл, хэсэг, заалтыг тусгасан байна. Үүнд:

- Ойн сан ангилал дэглэм /Ойн сан бүхий газар, ойн бүсийн ангилал, ойн тооллого, ойн зохион байгуулалт, хамгаалалтын бүсийн ой түүний, дэглэм, ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм, тусгай зориулалтын ой, түүний дэглэм/
- Ойн менежмент / Ойн тогтвортой менежментийн зарчим, Ойн менежментийн төлөвлөгөө, Улсын ойн менежментийн төлөвлөгөө, аймаг нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө, сумын ойн менежментийн төлөвлөгөө, хушин ойн менежмент/
- Ойн эдийн засаг / Таримал ойг өмчлөх, эзэмшиж ашиглах,Ойн сан бүхий газрыг хариуцуулах, ойн эдийн засгийн үйл ажиллагаа, ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мод бэлтгэх, ойн модны нөөцийг ашиглуулах, ойн модны нөөц ашиглуулах гэрээ, мод боловсруулах үйлдвэрлэл, ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, боловсруулах, био- эдийн засгийн үйлдвэрлэл, төрөөс үзүүлэх дэмжлэг/
- Ойжуулалт, нөхөн сэргээх /ойн үр, үржлийн материал бэлтгэх, ойжуулалт, нөхөн сэргээлт, агро- аж ахуй, бүх нийтээр мод, сөөг тарьж ургуулах ажлыг зохион байгуулах/
- Төрийн байгууллагын бүрэн эрх / Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ойн талаарх бүрэн эрх, Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх , Сумын болон сум дундын ойн ангийн чиг үүрэг , Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх, Сумын Засаг даргын бүрэн эрх, Салбар дундын уялдаа, хамтын ажиллагаа/
- Ойг хамгаалах, нөхөн сэргээхэд хүн хуулийн этгээдийн оролцоо/ мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, нөхөрлөл, иргэний эрх үүрэг, ой бүхий нутгийн иргэдийн эрх, орон нутгийн давуу эрх/
- Ойн мэдээллийн цахим систем, хяналт /Ойн мэдээллийн цахим систем, Ойн салбарын хяналт, ил тод байдал/
- Санхүүжилт, сан, хөрөнгө оруулалт /Санхүүжилтийн эх үүсвэр, Ойжуулалтын сан, Ойжуулалтын сангийн эх үүсвэр, Нүүрстөрөгчийн сан, Ойн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцоо/
- Бусад / Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт, Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага/

Иймд хуулийн төслөөс зохицуулалтуудыг сонгохдоо дээрх агуулгыг бүхэлд нь хамруулж, Аргачлалын 3.2-т заасны дагуу хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзье.

2.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний[4] тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгааг судалдаг.

Иймд Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 1. Зорилгод хүрэх байдал: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

№	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслөөс сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Хуулийн төслийн зохицуулалт нь Ойн тухай хуулийн зорилтод нийцэх эсэх, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	**5 дугаар зүйл.**Төрөөс ойн талаар баримтлах зарчим 5.1.Төрөөс ойн талаар дараах зарчмыг баримтална: 5.1.1.Монгол Улсын ой төрийн хяналт, хамгаалалтад байх; 5.1.2.ойн нөөцийг ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах; 5.1.3.ойн нөөцийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу зориулалтаар нь үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх; 5.1.4.ойн экосистемийн үйлчилгээ хүртээмжтэй байх, ойн эдийн засгийг дэмжих; 5.1.5.ойн менежментийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах.
2.	Хуулийн төслийн зохицуулалт нь Ойн тухай хуулийн зорилтод нийцэх эсэх, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	6.1.Ойн сан бүхий газарт ой, мод, сөөг бүхий газар, заг бүхий газар, ойн цоорхой, цагаан энгэр, доройтсон ойн талбай, ой тэлэн ургахад шаардлагатай талбай, ой доторх мод үржүүлгийн талбай, ойн нөхөн сэргээлт хийсэн талбай, ойн түймрээс хамгаалах зурвас гаргасан талбай, таримал ойн эзлэх талбай хамаарна.
3.	Хуулийн төслийн зохицуулалт нь Ойн тухай хуулийн зорилтод нийцэх эсэх, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл	7.1.Ойн нөөц, экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн бүсийг дор дурдсанаар ангилна: 7.1.1.хамгаалалтын бүсийн ой; 7.1.2.ашиглалтын бүсийн ой; 7.1.3.тусгай зориулалтын ой.

[4] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал

	боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	
4.	Хуулийн төслийн зохицуулалт нь Ойн тухай хуулийн зорилтод нийцэх эсэх, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	49.1.Ойн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мониторинг хийх, ойн тооллого, ой зохион байгуулалт, ойн мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн оролцоог дэмжих, салбарын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор ойжуулалтын сантай байна.
5.	Хуулийн төслийн зохицуулалт нь Ойн тухай хуулийн зорилтод нийцэх эсэх, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	51.1.Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, орлогын хуваарилалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор Нүүрстөрөгчийн сантай байж болно.

2.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг

"Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулга бүхий зохицуулалтын үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Ойн тооллогыг улсын хэмжээнд арван жил тутам явуулна, ойн тооллогоор ойн экосистемийн нүүрстөрөгчийн шингээлт, ялгарал, биологийн олон янз байдал, ховор болон нэн ховор зүйл, тэдгээрийн амьдрах орчинг тодорхойлно гэж зохицуулсан нь практикт хэрэгжих боломжтой эсэх.	**8 дугаар зүйл.Ойн тооллого** 8.1.Ойн тооллогыг улсын хэмжээнд арван жил тутам явуулна. 8.2.Ойн тооллогоор ойн экосистемийн нүүрстөрөгчийн шингээлт, ялгарал, биологийн олон янз байдал, ховор болон нэн ховор зүйл, тэдгээрийн амьдрах орчинг тодорхойлно.
2.	Ашиглалтын бүсийн ойгоос бэлтгэсэн, гарал үүсэл нь тодорхой түүхий эдэд тулгуурлан холбогдох стандарт, техникийн зохицуулалтын дагуу мод боловсруулах үйлдвэрлэлийг явуулна, мод боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь үйлдвэрлэлийн үйл явцад энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийлгэж болно гэж зохицуулсан нь практикт хэрэгжих боломжтой эсэх	**26 дугаар зүйл.Мод боловсруулах үйлдвэрлэл** 26.1.Ашиглалтын бүсийн ойгоос бэлтгэсэн, гарал үүсэл нь тодорхой түүхий эдэд тулгуурлан холбогдох стандарт, техникийн зохицуулалтын дагуу мод боловсруулах үйлдвэрлэлийг явуулна. 26.2.Мод боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь үйлдвэрлэлийн үйл явцад энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийлгэж болно.
3.	Хушин ойн менежментийн талаар зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжтой эсэх	**18 дугаар зүйл.Хушин ойн менежмент** 18.1.Хушин ой нь экологийн хувьд эмзэг, эдийн засгийн ач холбогдолтой тул тусгайлсан

		менежментийн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ: 18.1.1.самрын нөөц, ашиглах хэмжээ, хугацаа, квот тогтоох; 18.1.2.механик гэмтлээс хамгаалах; 18.1.3.байгалийн сэргэн ургалтыг дэмжих; 18.1.4.хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт тавих; 18.1.5.түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх; 18.1.6.хөрс, үндсийг хамгаалах; 18.1.7.самрыг зохистой ашиглах; 18.1.8.доройтсон талбайд нөхөн сэргээлт хийх
4.	Байгаль орчны тэнцвэр, ус, хөрс, уур амьсгал, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсийн ойг тогтооно гэж зохицуулсан нь практикт хэрэгжих боломжтой эсэх	10.1.Байгаль орчны тэнцвэр, ус, хөрс, уур амьсгал, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсийн ойг тогтооно. 10.2.3.тусгай хамгаалалттай газрын ой;
5.	Хамгаалалтын бүсийн ойд хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно гэзд экологийн боловсрол, танин мэдэхүй, зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал гэж зохицуулсан нь практикт хэрэгжих боломжтой эсэх.	10.3.Хамгаалалтын бүсийн ойд хуульд заасан үндэслэл журмын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно: 10.3.6.экологийн боловсрол, танин мэдэхүй, зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал;
6.	Хушин ойд иргэн, хуулийн этгээдээс дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно гэзд механик аргаар самар бэлтгэх гэж зохицуулсан нь практикт хэрэгжих боломжтой эсэх	18.2.Хушин ойд иргэн, хуулийн этгээдээс дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно: 18.2.1.механик аргаар самар бэлтгэх; 18.2.2.байгалийн сэргэн ургалтыг устгах; 18.2.3.хөрс, үндэс гэмтээх; 18.2.4. зөвшөөрөлгүй ашиглах.
7.	Таримал ойг өмчлөх, эзэмших, ашиглах талаар зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжтой эсэх	19.1.Дараах газарт иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр ой, модыг тарьж ургуулж, үр шимийг хүртэж болно: 19.1.1.Монгол Улсын иргэн өмчлөлийн газартаа; 19.1.2.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа; 19.1.3.улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт. 19.2.Монгол Улсын иргэн өмчлөлийн газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, модыг өмчилж болно.

	19.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, модыг эзэмшиж ашиглаж болно.

2.3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг

"Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, тухайн төсөл хэл зүй, найруулгын шаардлага хангасан эсэх, үг сонголтын хувьд оновчтой, ойлгомжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай бичигдсэн эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томьёоны тодорхойлолттой холбоотой хэсэг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэлгээ хийв.

Хүснэгт 3.Ойлгомжтой байдал: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой томьёолсон эсэх, логик дараалалтай боловсруулсан эсэх	Хуулийн төслийг бүхэлд нь

2.4. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжид заасан зохицуулалт, тухайлбал хүлээх үүргийг хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэх, тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй нийгмийн харилцаа, эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас тэдгээрийн эрх үүрэг, ашиг сонирхол хөндөгдөх хэм хэмжээг сонгон авсан.

Хүснэгт 4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

№	*Хүлээн зөвшөөрөгдөх байдал*	*Сонгосон зүйл, хэсэг, заалт*
1.	Ойн модны нөөцийг ашиглуулах сонгох шалгаруулалтад оролцогчид тавигдсан шаардлага нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	24.3.Сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах шалгуурыг хангасан байна: 24.3.1.техникийн болон мэргэжлийн чадавх; 24.3.2.байгаль орчны менежментийн туршлага; 24.3.3.санхүүгийн чадавх; 24.3.4.нөхөн сэргээлтийн баталгаа; 24.3.5.орон нутгийн оролцоо, ашиг хүртээмжийн санал; 24.3.6.мэдээллийн ил тод байдал, тайлагналын чадавх.
2.	Ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах гэж зохицуулсан нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	20.2.7.ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах;

3.	Ой бүхий нутгийн иргэд, нөхөрлөл, малчин өрхийн анхдагч холбоо, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлд дараах үйл ажиллагаанд давуу эрх олгоно гэсэн шалгуур нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	46.2.Давуу эрх олгохдоо дараах шалгуурыг баримтална: 46.2.1.тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх; 46.2.2.хууль ёсны бүртгэлтэй байх; 46.2.3.сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай байх; 46.2.4.байгаль орчны зөрчилгүй, эсхүл зөрчлөө арилгасан байх.

2.5. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг тооцох хэсэг

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгоно. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцэх эсэхийг шалгаж, зөрчилтэй асуудлыг тайлагнана.

Хүснэгт 5. Харилцан уялдаа: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хуультай нийцэх эсэх	Хуулийн төслийг бүхэлд нь

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтов.

Хүснэгт 6. Шалгуур үзүүлэлт ба тохирох шалгах хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт-Үнэлэх хэсэг-Тохирох шалгах хэрэгсэл

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	- Хуулийн төслийн 5.1, 7.1, 6.1, 49.1,51.1 дэх хэсэг	Хуулийн төслийн зорилт, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	- Хуулийн төслийн 8.1, 8.2, 26.1, 26.2 ,18.1, 10.1, 10.3, 18.2, 19.1 дэх хэсэг	Баримт бичигт дүн шинжилгээ хийх, тохиолдол судлах хэлбэрээр зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг судлах
3.	Ойлгомжтой байдал	- Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн бичвэрийн агуулга, нэр томьёог тайлбарлах байдлаар ойлгомжгүй байдлыг сайжруулах болон хэл зүй, найруулгын шаардлагад нийцүүлэх санал гаргах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	- Хуулийн төслийн 24.3, 20.2.7, 46.2 дахь хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодруулах үүднээс бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон бусад судалгааны эх сурвалжийн хүрээнд дүн шинжилгээ хийх
5.	Харилцан уялдаа	- Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн хэм хэмжээ хоорондоо харилцан уялдаатай эсэх, Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж буй

	эсэх, бусад хууль тогтоомжтой харилцан уялдаатай эсэхийг нягтлах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

"Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томьёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулж дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд дараах заалтуудад дүн шинжилгээ хийе.

3.1.1 Хуулийн төслийн 5 дугаар зүйл

5 дугаар зүйл.Төрөөс ойн талаар баримтлах зарчим
5.1.Төрөөс ойн талаар дараах зарчмыг баримтална:
5.1.1.Монгол Улсын ой төрийн хяналт, хамгаалалтад байх;
5.1.2.ойн нөөцийг ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;
5.1.3.ойн нөөцийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу зориулалтаар нь үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;
5.1.4.ойн экосистемийн үйлчилгээ хүртээмжтэй байх, ойн эдийн засгийг дэмжих;
5.1.5.ойн менежментийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Ойн тухай хуульд төрөөс ойн талаар баримтлах зарчмын талаар тухайлан зохицуулж өгөөгүй байсан. Харин энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд төрөөс ойн талаар баримтлах зарчмыг тодорхой болгон зохицуулсан нь сайшаалтай байна. Ойн тухай хуулийн өнөөгийн зорилго нь ойг хамгаалах, нөхөн сэргээх тогтвортой ашиглах замаар экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоонд тулгуурласан менежментийг хөгжүүлэхэд чиглэдэг. Энэ утгаараа Монгол Улсын ой төрийн хяналт, хамгаалалтад байх, ойн нөөцийг ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах, ойн нөөцийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу зориулалтаар нь үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх; ойн экосистемийн үйлчилгээ хүртээмжтэй байх, ойн эдийн засгийг дэмжих; ойн менежментийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах гэдэг нь зорилгын шинжтэй заалтууд байх тул зарчмын ойлголтыг хууль ёсны зарчим, шударга ёсны зарчим гэх мэтээр ангилан аль зарчимд аль зүйл, хэсэг, заалт хамаарч байгаагаар нарийвчилж хуульчлах хэрэгтэй тул хамаарах зохицуулалтыг уялдуулан төсөлд тусгах шаардлагатай. Үүнийг хүрээнд нэр томьёог мөн дахин хянах шаардлагатай байна.

3.1.2 Хуулийн төслийн 6 дугаар зүйл

6.1.Ойн сан бүхий газарт ой, мод, сөөг бүхий газар, заг бүхий газар, ойн цоорхой, цагаан энгэр, доройтсон ойн талбай, ой тэлэн ургахад шаардлагатай талбай, ой доторх мод үржүүлгийн талбай, ойн нөхөн сэргээлт хийсэн талбай, ойн түймрээс хамгаалах зурвас гаргасан талбай, таримал ойн эзлэх талбай хамаарна.

Ойн сан бүхий газарт ой, мод, сөөг бүхий газар, заг бүхий газар, ойн цоорхой, цагаан энгэр, доройтсон ойн талбай, ой тэлэн ургахад шаардлагатай талбай, ой доторх мод үржүүлгийн талбай, ойн нөхөн сэргээлт хийсэн талбай, ойн түймрээс хамгаалах зурвас гаргасан талбай, таримал ойн эзлэх талбайг оруулан хуульчилж өгсөн нь уг асуудлыг илүү тодорхой болгон зохицуулж өгсөн байна.

Монгол Улсын ойн сан 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрдэнэ. Ойн сангийн нийт талбайн хэмжээ 18.29 сая га бөгөөд, үүний 75.3 хувьд шилмүүст, навчит ой 24.7 хувьд заган ой ургаж, улсын нийт нутаг дэвсгэрийн 8.2 хувийг ой эзэлдэг. Говь цөлийн бүсэд ургадаг заган ойг оруулахгүйгээр улсын нутаг дэвсгэрийн умард хэсгийн ойгоор бүрхэгдсэн талбай 10.68 сая га байна.[5] Монгол улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ой, ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн суулгац бойжуулах мод үржүүлгийн газар эзлэх талбай зэрэг ордог. [6] Ойн сан бүхий газарт мод, сөөг бүхий талбай, түр хугацаанд модгүй болсон ойн талбай, ойн нөхөн сэргээлтийн талбай, таримал ой, мод үржүүлгийн газар зэрэг хамаардаг. [7] Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "ойн сан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг ойлгоно гэжд мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг тодорхойлсон байна. Уг шинэчилсэн хуулийн төслөөр уг 2 заалтыг нэгтгэн зохицуулсан байна. Иймд ойн сангийн зохицуулалтыг нэгтгэн тодорхойлж илүү нарийвчлан зохицуулсан нь сайшаалтай байна.

3.1.3 Хуулийн төслийн 7 дугаар зүйл

7.1.Ойн нөөц, экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн бүсийг дор дурдсанаар ангилна:

7.1.1.хамгаалалтын бүсийн ой;

7.1.2.ашиглалтын бүсийн ой;

7.1.3.тусгай зориулалтын ой.

Ойн сангийн ангилалд ойн санг экологи- эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзах дараах байдлаар ангилна гэж онцгой бүсийн ой, хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой гэж ангилсан байдаг.[8] Ойн тухай хуулийн зорилго нь Монгол Улсын ойг хамгаалах , нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших , ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Уг заалтын хүрээнд ойн нөөц, экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн бүсийг 3 ангилсан[9] нь менежментийг илүү тодорхой болгож, экосистемийг хамгаалах боломжийг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэх магадлалтай байна. Ойг үндсэн зориулалтаар нь хамгаалалтын ой (protection forest), ашиглалтын ой (production forest), тусгай зориулалтын ой (special-use forest) гэж ангилдаг.[10] Хамгаалалтын бүсийн ой нь экологийн тэнцвэрийг хангах, ус, хөрс хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чухал ач холбогдолтой ойн сан бүхий газар юм. Ашиглалтын бүсийн ойг хамгаалалтын бүсийн ойгоос бусад бүсийг ойлгохоор хуульчлахаар тусгасан байна. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ойн нөөцийг хамгаалах, хот, суурины ногоон бүсийг хөгжүүлэх, түүх, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, нийгмийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор тусгай зориулалтын ойг тогтооно гэж тусгажээ. Харин сул тал нь уян хатан бус байдал болон төрийн байгууллагын ачаалал одоо байгаагаас нэмэгдэх юм. Тусдаа төлөвлөгөө, хяналт, зөвшөөрөл авах зэргээр захиргааны болон тухайн ойнд хэрэгжүүлэх менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал нэмэгдэх, шаардлагатай тул төрийн байгууллагын ачаалал энэ хэрээр ихсэх

[5] Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл., /ШУТИС/, 3/74, УБ, 2005. 25-р тал

[6] Экологийн эрх зүй, Т.Сэнгэдорж , 2007 он;

[7] FAO, Global Forest Resources Assessment: Terms and Definitions, 2020, https://www.fao.org/4/ap862e/ap862e00.pdf, (Сүүлд үзсэн: 2026.05.07);

[8] Мөн тэнд;

[9] Forests are classified into three categories according to their main use purposes as follows:

a/ Special-use forests, which are determined for the purpose of preserving the nature, standard specimens of the national forest ecological system, gene sources of forest flora and fauna, conducting scientific research, protecting historical and cultural relics and scenic places, and catering for rest, recreation and tourism;

b/ Protection forests, which are determined primarily for forest construction and development aiming to protect and regulate water sources, protect soil, combat erosion, limit natural calamities, make the climate equable, ensure ecological balance and environmental security;

c/ Production forests, which are determined primarily for forest construction and development aiming to produce and trade in forest products (particularly timber and forest specialties) in combination with protecting the environment and ecological balance.

[10] Law No. 29/2004/QH11 of December 03rd, 2004, on Forest Protection and Development.

магадлалтай. Иймд тус хуулийн зорилгод менежментийг илүү тодорхой болгосноороо, тусгайлсан шинэ ангиллыг бий болгож, хамгаалах, зохистой ашиглахтай холбоотой менежментийн нэвтрүүлж байгаагаараа нийцэж байна.

3.1.4.Хуулийн төслийн 49 дүгээр зүйл

49 дүгээр зүйл. Ойжуулалтын сан

49.1.Ойн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мониторинг хийх, ойн тооллого, ой зохион байгуулалт, ойн мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн оролцоог дэмжих, салбарын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор ойжуулалтын сантай байна.

Ойн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мониторинг хийх, ойн тооллого, ой зохион байгуулалт, ойн мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн оролцоог дэмжих, салбарын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор ойжуулалтын сантай байхаар зохицуулсан нь ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахтай холбоотой үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх зорилготой байна. Уг зохицуулалтаар ойг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мониторинг, ойн тооллого, ой зохион байгуулалт систем, цахим мэдээллийн систем, орон нутгийн оролцоо, тогтвортой санхүүжилт гэх олон чиг үүргийг нэг сангаар дамжуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлжээ. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, экологийн аюулгүй байдлыг хангах нь нийтийн эрх ашиг хамгаалах чиг үүрэгтэй буюу Монгол Улсын Үндсэн хуулийн байгаль орчноо хамгаалах, иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй уялдаж байна.

Салбарын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх гэж заасан нь зөвхөн төсвөөс хараат бус, урт хугацааны, зориулалтын санхүүжилтийн тогтолцоо бий болгох зорилготой ба байгаль орчны төлбөр, нөхөн төлбөр, олон улсын төсөл хөтөлбөр, нүүрстөрөгчийн санхүүжилт, ойн экосистемийн үйлчилгээний төлбөр зэрэгтэй уялдаа холбоотой юм.

Эрх зүйн эрсдэл, анхаарах асуудлын хүрээнд хөрөнгийн эх үүсвэр, төвлөрүүлэх журам, зарцуулах шалгуур, хяналтын тогтолцоог илүү нарийвчлан зохицуулах нь зүйтэй. Эрх зүйн үр нөлөөг бүрэн хангахын тулд сангийн бүтэц, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалтын шалгуур, хяналт, олон нийтийн оролцоо, тайлагналын механизмыг илүү боловсронгуй болгох нь зүйтэй юм. Түүнчлэн сангийн хөрөнгийн зарцуулалтын хэлбэр, түүнийг хэрхэн зохион байгуулах механизмыг бий болгох хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах байдлаар тусгах нь зүйтэй.

3.1.5.Хуулийн төслийн 51 дүгээр зүйл.

51 дүгээр зүйл. Нүүрстөрөгчийн сан

51.1.Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, орлогын хуваарилалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор Нүүрстөрөгчийн сантай байж болно.

Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, орлогын хуваарилалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор Нүүрстөрөгчийн сантай байж болно гэж зохицуулсан нь ойн экосистемийн нүүрстөрөгч шингээх чадавхыг эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсын болон дотоодын нүүрстөрөгчийн зах зээлд оролцож хөрөнгө төвлөрүүлэх, эргээд энэхүү сангаас ойг нөхөн сэргээх, ойжуулалтын арга хэмжээнд зарцуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн зохицуулалт болжээ. Энэхүү заалтын зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх, нүүрстөрөгчийн зах зээлийн механизмыг хөгжүүлэх,

байгаль хамгааллыг эдийн засгийн үнэлэмжтэй холбох, олон улсын санхүүжилт татах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэж байна.

Тус зохицуулалтын хүрээнд "сантай байж болно" гэж зохицуулсан нь заавал байгуулах императив шинжгүй, боломжит буюу диспозитив зохицуулалттай, Засгийн газар болон эрх бүхий байгууллагад бодлогын сонголтын эрх олгогдсон байх тул сан байгуулах эсэх, бүтэц, санхүүжилтийн эх үүсвэр, удирдлагын тогтолцоо нь холбогдон гарах, дагах журам, бодлогоос хамаарах эрх зүйн орчинг бий болгож байна. Орлогын хуваарилалттай холбоотой авилга, ашиг сонирхлын зөрчил, төвлөрсөн удирдлагын эрсдэл үүсэх магадлалтай байх тул аудит нээлттэй тайлагнал, олон нийтийн хяналтын тогтолцооны эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай. Төслөөс харахад энэхүү сан нь Засгийн газрын тусгай сан байх тул Засгийн газрын газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах байдлаар сангийн эх үүсвэр, зарцуулалт, тайлагналт, хяналт болон ажлын албатай байх эсэх зэргийг тодорхой болгох шаардлагатай байна.

Нүүрстөрөгчийн эрх (carbon rights)-ийг хэн эзэмших нь дэлхийн эрх зүйн орчинд тодорхойгүй хэвээр байна.[11]

Нүүрстөрөгчийн эзэмшил болон түүнтэй холбоотой эрхийн талаарх эрх зүйн болон зохицуулалтын орчныг тодорхой болгох нь тухайн улс REDD+ хэрэгжүүлэхэд бэлэн болоход зайлшгүй шаардлагатай. Ялангуяа хөгжиж буй ихэнх орнууд дотоодын хууль тогтоомждоо нүүрстөрөгчийн эзэмшил болон эрхийн асуудлыг одоог хүртэл тодорхойлоогүй байна.[12]

Нүүрстөрөгчийн эрх болон ойн газрын эзэмшил нь ихэвчлэн давхацдаггүй. Энэ нь практикт асуудал үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, хэн нэгэн ойн газрыг өмчилж байж болох ч тухайн ойн нүүрстөрөгчийн нөөцийг өмчлөх эрхгүй байх боломжтой.

Уг нүүрстөрөгчийн сан нь нүүрстөрөгчийн зах зээлийг хөгжүүлэх, ойн экосистемийн эдийн засгийн үнэлгээг бий болгох, олон улсын ногоон санхүүжилт татах, уур амьсгалын бодлогыг хэрэгжүүлэх стратегийн чухал ач холбогдолтой зохицуулалт юм. Гэвч бүрэн хэрэгжихийн тулд нүүрстөрөгчийн өмчлөлийн эрх, бүртгэлийн тогтолцоо, орлогын хуваарилалт, хяналт, баталгаажуулалтын стандарт, олон улсын зах зээлийн нийцэл зэрэг асуудлыг дагалдах журам болон тухайлсан эрх зүйн актаар нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна.

3.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

"Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих боломжтой эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн дараах хэсэг, заалтад дүн шинжилгээ хийе.

3.2.1 Хуулийн төслийн 8 дугаар зүйл

8 дугаар зүйл.Ойн тооллого

8.1.Ойн тооллогыг улсын хэмжээнд арван жил тутам явуулна.
8.2.Ойн тооллогоор ойн экосистемийн нүүрстөрөгчийн шингээлт, ялгарал, биологийн олон янз байдал, ховор болон нэн ховор зүйл, тэдгээрийн амьдрах орчинг тодорхойлно.

[11] Day, C.; Naughton–Treves, L. Introduction lessons from early efforts to secure land tenure within forest carbon management projects. In *Lessons about Land Tenure, Forest Governance and REDD+: Case Studies from Africa, Asia and Latin America*; Naughton-Treves, L., Day, C., Eds.; UW-Madison Land Tenure Center: Madison, WI, USA; pp. 1–10.

[12] Parrotta, J.A.; Gardner, T.; Kapos, V.; Kurz, W.A.; Mansuorian, S.; McDermott, C.L.; Strassburg, B.B.N.; Thompson, I.D.; Vira, B.; Wildburger, C. *Understanding Relationships between Biodiversity, Carbon, Forests and People: The Key to Achieving REDD+ Objectives*; IUFRO World Series; Vienna, Austria, 2012; Volume 31, pp. 13–20. [Google Scholar]

Ойн тооллогыг улсын хэмжээнд арван жил тутам явуулна гэж заасан нь улсын хэмжээнд ойн нөөцийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, төрийн бодлого төлөвлөлтийг бодит мэдээлэлд тулгуурлах боломжийг бүрдүүлдэг давуу талтай. Ингэснээр ойн хэмжээ, доройтол, нөхөн сэргээлтийн түвшин, ашиглалтын нөлөөллийг урт хугацаанд харьцуулан үнэлэх нөхцөл бүрдэнэ. Мөн тогтмол тооллого хийх нь ойн нөөцийн өөрчлөлтийг хянах, хууль бус ашиглалт болон экологийн эрсдэлийг илрүүлэхэд ач холбогдолтой байна. Харин мод тооллогыг 10 жил тутамд явуулах нь урт хугацаа байж болох бөгөөд энэ хугацаанд ойд их хэмжээний өөрчлөлт гарч давагдашгүй хүчин зүйл бий болох эрсдэлтэй байна. Олон улсын ойн мониторингийн чиг хандлагаас үзэхэд үндэсний ойн тооллогыг 5 жилийн давтамжтай хийх нь түгээмэл болж байна.[13]

Ой мод цаг хугацааны явцад хурдан өөрчлөгдөж болох тул тогтмол дахин үнэлгээ хийх шаардлагатай байдаг. Иймээс хугацааны давтамж нь үндэсний ойн тооллогын (NFI) загвар, зохион байгуулалтын үндсэн бүтэц болдог. Үүнтэй холбоотойгоор дэлхийн ихэнх улсын үндэсний ойн тооллогыг XX зууны туршид ихэвчлэн 10 жилийн урьдчилан тогтоосон мөчлөгөөр хэрэгжүүлж ирсэн (Tomppo et al. 2010). Харин НҮБ/ХХААБ-ын Дэлхийн ойн нөөцийн үнэлгээ (FRA), мөн 1990 оноос хэрэгжиж буй Европын ойн тайлагналын тогтолцоо (MCPFE/Forest Europe protocol) зэрэг олон улсын ойн тайлагналын үйл ажиллагаа нь 5 жилийн тайлагналын давтамжийг түлхүү хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь ойн статистикийг илүү богино хугацааны мөчлөгөөр гаргах шаардлагыг бий болгож байна.[14]

Иймд ойн тооллого нь ойн экосистемийн нүүрстөрөгчийн шингээлт, ялгарал биологийн олон янз байдал, ховор болон нэн ховор зүйл, тэдгээрийн амьдрах орчинг тодорхойлох чухал үйл ажиллагаа байх тул ойн тооллогыг 5 жил тутамд нэг хийх нь экологийн хувьд зүйтэй байх тул практикт хэрэгжихэд хүндрэлтэй байна.

3.2.2 Хуулийн төслийн 26 дугаар зүйл

26 дугаар зүйл. Мод боловсруулах үйлдвэрлэл

26.1.Ашиглалтын бүсийн ойгоос бэлтгэсэн, гарал үүсэл нь тодорхой түүхий эдэд тулгуурлан холбогдох стандарт, техникийн зохицуулалтын дагуу мод боловсруулах үйлдвэрлэлийг явуулна.

26.2.Мод боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь үйлдвэрлэлийн үйл явцад энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийлгэж болно.

23.8.Ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг аймаг, сум, хот, суурины хоорондтэвэрлэх, худалдахдаа цахим гарал үүслийн гэрчилгээтэй байна. Гэрчилгээг тухайн орон нутгийг хариуцсан ойн анги цахим системээр олгоно.

Мод бэлтгэх гэрээ байгуулахдаа мод бэлтгэх аж ахуйн нэгж, байгууллага нь мод бэлтгэх тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Төрийн захиргааны байгууллага нь мод бэлтгэх, техник, технологийн болон мод ашиглалтын түвшин ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийн хэмжээ аймгийн Засаг даргын санал, дүгнэлтийг харгалзан уг асуудлыг шийдвэрлээд хэрэв зөвшөөрвөл аж ахуйн нэгж нь сумын Засаг дарга эсвэл аймгийн Засаг даргын томилсон албан тушаалтантай гэрээ байгуулна. Ахуйн зориулалтаар мод бэлтгэх эрх үүсэх журмын хүрээнд иргэн аж ахуйн нэгж байгууллагын хэрэглээний мод бэлтгэх хүсэлтийг сумын Засаг даргад гаргах бөгөөд тухайн Засаг даргаас боломжтой гэж үзвэл эрхийн бичгийг олгоно. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын түлээ бэлтгэх хүсэлтийг байгаль хамгаалагчид гаргаж болно гэж үзвэл эрхийн бичгийг олгоно. [15] Мод боловсруулах үйлдвэрлэлийг ойн нөөцийн үнэлгээ, ашиглалтын хэмжээ, менежментийн төлөвлөгөө, тогтвортой хангамжид тулгуурлуулах нь ойг хэт ашиглахаас сэргийлж, шинжлэх ухаанд суурилсан ашиглалтыг хангаж байна. Зөвхөн хууль ёсны, ашиглалтын бүсийн түүхий

[13] Take five: about the beat and the bar of annual and 5-year periodic national forest inventories, Annals of Forest Science
[14] Take five: about the beat and the bar of annual and 5-year periodic national forest inventories, Annals of Forest Science
[15] Экологийн эрх зүй, Т.Сэнгэдорж, 2007 он, 143-р тал

эд ашиглах шаардлага нь хууль бус мод бэлтгэлийг хязгаарлах, ойг хамгаалах зорилготой шууд нийцнэ. Харин практикт учрах эрсдэл нь ойн нөөцийн үнэлгээ бодит, шинэчлэгдсэн мэдээлэл хангалтгүй, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт сул байх эрсдэлтэй байна. Мод бэлтгэл зөвшөөрөл, гарал үүслийн бичиг баримтыг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар шаарддаг. Гэвч хууль бус модны эргэлт тодорхой хэмжээнд байсаар байна. Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаагаар ойн ашиглах нөөцийн хэмжээнээс хэд дахин бага мод ашиглах тоо хэмжээг шат дамжлагаар багасган тогтоодог. Мөн хэрэгцээ, ашиглах, хэрэглэх тооц хэмжээний уялдаагүй байдлаар болж, хууль бусаар мод, түлээ ашиглах нь хэвээр байгаа талаар тоо баримттай дурдсан байдаг. Иймд ойн нөөцийг судалгааны үндсэн дээр нөөц даацад тохирсон ашиглалтыг явуулах тоо хэмжээг тогтоох, ялангуяа ашиглалтын бүсийн ойгоос бэлтгэсэн, гарал үүсэл нь тодорхой түүхий эдэд тулгуурлан үйлдвэрлэл явуулахыг заасан нь мод боловсруулах үйлдвэрлэлийг хууль ёсны эх үүсвэртэй болгож өгч, ойн нөөц даацад тулгуурлан нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах давуу талтай байна. Харин энэхүү жилд ашиглах, хэрэглэх тоо хэмжээг тогтоох болон зөвшөөрлийг авах, гарал үүслийн эрхийн бичгийг авах үйл ажиллагааг нарийвчлан төсөлд тусгах нь зүйтэй байна. Ингэснээр зөвшөөрөл олгохтой холбоотой харилцаа, зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагааг нарийвчлан зохицуулснаар авлига ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэх юм.

Харин дээрх төсөлд тусгасан процесс ажиллагаа нь практикт жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд стандарт болон техникийн шаардлага тавигдах тул өндөр зардал, дарамт учирч болзошгүй байгааг анхаарч үзэх.

3.2.3 Хуулийн төслийн 18 дугаар зүйл

18 дугаар зүйл.Хушин ойн менежмент

18.1.Хушин ой нь экологийн хувьд эмзэг, эдийн засгийн ач холбогдолтой тул тусгайлсан менежментийн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

18.1.1.самрын нөөц, ашиглах хэмжээ, хугацаа, квот тогтоох;
18.1.2.механик гэмтлээс хамгаалах;
18.1.3.байгалийн сэргэн ургалтыг дэмжих;
18.1.4.хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт тавих;
18.1.5.түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх;
18.1.6.хөрс, үндсийг хамгаалах;
18.1.7.самрыг зохистой ашиглах;
18.1.8.доройтсон талбайд нөхөн сэргээлт хийх.

Тусгайлсан менежментийн арга хэмжээ нь экологийн экосистемийг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, самрын нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах, ой доройтохоос урьдчилан сэргийлэх, нийтийн болон ирээдүй үеийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго, ач холбогдолтой байна. Самрын нөөц, ашиглах хэмжээ, хугацаа, квот тогтоох арга хэмжээ нь хэт ашиглалтаас сэргийлэх, зөвшөөрөл, квотын систем бий болгох, нөөцийн даацад суурилсан ашиглалтыг хэрэгжүүлэх бөгөөд төрийн байгууллага уг арга хэмжээний хүрээнд тооллого хийх, үнэлгээ тогтоох, зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх хэмжээ үүснэ. Төсөлд тусгасан механик гэмтлээс хамгаалах арга хэмжээ нь хуш модыг цохих, мөчир хугалах, мод гэмтээх аргаар самар түүхийг хориглох эрх зүйн үндэслэл болно. Байгалийн сэргэн ургалтыг дэмжих нь залуу мод хамгаалах, хөрс хамгаалах гэх мэт арга хэмжээг ойлгоно. Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт тавих зохицуулалт нь ил тод байдал, хараат бус үнэлгээ, байгаль орчны мониторинг хийх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Энэхүү арга хэмжээнүүд нь урьдчилан сэргийлэх шинжтэй, нөөц ашиглалтын тэнцвэрийг хангасан, төрийн болон ашиглагчийн хариуцлагыг тодорхойлсон байна. Гэвч хориглосон, хязгаарласан хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаар төсөлд нарийвчлан

тусгаагүй байна. Энэ нь хуулийг нэг мөр хэрэглэх, Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй зарчимд нийцэж, хууль хоорондын уялдааг хангах нөхцөл болох юм. Зүй нь дээрх хориглосон, хязгаарласан хэм хэмжээнээс ямар үйлдлийг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчилд хамаарахыг Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй юм.

Түүнчлэн зохистой ашиглах, механик гэмтэл, хөндлөнгийн хяналт зэргийг журам, стандарт, аргачлалаар нарийвчлан тогтоохоос илүүтэй Улсын Их Хурал, Засгийн газрын хууль тогтоомжийн талаар баримтлах бодлого, чиглэл, хууль зүйн нэгдсэн бодлогод тулгуурлан хуулийн төсөлд нарийвчлан тусгах нь зүйтэй.

Ойн экосистемийн онцлог, самрын эдийн засгийн өндөр ач холбогдлыг харгалзан үзсэн зохицуулалт бөгөөд байгаль хамгаалалт болон тогтвортой ашиглалтыг зэрэг хангах зорилготой гэж үзэж болно. Экологийн хувьд эмзэг, эдийн засгийн ач холбогдолтой гэж тусгайлан тодорхойлсон нь хушин ойг ердийн ашиглалтын ойтой адилтгахгүйгээр тусгай хамгаалалт, менежмент шаардлагатай нөөц гэж хуульчилсан байх тул сайшаалтай байна. Ялангуяа төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д самрын нөөц, ашиглах хэмжээ, хугацаа, квот тогтоохоор заасан нь самрын хэт ашиглалтыг бууруулах, байгалийн нөөцийг нөхөн сэргээгдэх боломжтой хэмжээнд ашиглах үндэс болохоос гадна хууль бусаар түүх, борлуулахаас урьдчилан сэргийлэх юм. Энэ нь тогтвортой ашиглалтын зарчимтай нийцэж байна. Гэвч уг зохицуулалт нь нэг талаараа хушин ойн менежменттэй холбоотой харилцааг бүхэлд нь зохицуулахад хэт ерөнхий тунхгийн шинжтэй, хууль зүйн үр дагавар үүсгэхгүй зохицуулалт болжээ. Иймд эдгээр зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй байдлаар, процесс ажиллагааг нарийвчлан тусгах байдлаар зохицуулах шаардлагатай байна.

3.2.4 Хуулийн төслийн 10 дугаар зүйл

10.1.Байгаль орчны тэнцвэр, ус, хөрс, уур амьсгал, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсийн ойг тогтооно.

10.2.3.тусгай хамгаалалттай газрын ой;

10.3.Хамгаалалтын бүсийн ойд хуульд заасан үндэслэл журмын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

10.3.1.ой хамгаалах;

10.3.2.арчилгаа, цэвэрлэгээ;

10.3.3.түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ;

10.3.4.нөхөн сэргээлт, ойжуулалт;

10.3.5. шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ;

10.3.6.экологийн боловсрол, танин мэдэхүй, зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал;

10.3.7.орон нутгийн иргэдийн ахуйн хэрэгцээний түлээний мод авах, хашаа хороогоо сэлбэх.

10.3.8.татмын ойд нөхөн сэргээх.

Тус хуулийн төслийн хүрээнд одоо хэрэгжиж буй Ойн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасан хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой гэж ангилсныг шинэчилсэн найруулгаар хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой, тусгай зориулалтын ой гэж нэг шинэ ангиллыг бий болгож тусгасан байна. Харин тус шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлийн 10.2.3 -т тусгай хамгаалалттай газрын ойг хамгаалалтын бүсийн ойд хамааруулж, төслийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4-т дэглэмийг тогтоохоор тусгасан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж ангилсан байдаг. Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 -т ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох бүрэн эрхийг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар хуульчилсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх зэргийг хуульчилсан байдаг. Харин хуулийн төсөлд тусгаснаар хамгаалалтын бүсийн ойд зөвхөн дээр дурдсан 8 төрлийн үйл ажиллагааг явуулж болохоор тусгасан нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуультай уялдахгүй байна. Тодруулбал, тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолбор газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газар гэж ангилагдах бөгөөд тус бүр өөрийн дэглэмтэй.

Тэгэхээр тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал тус бүрийн дэглэм, хамгаалалтын бүсийн ойн дэглэмтэй зөрчилдөх, ойн тусгай хамгаалалттай газар нутагт одоогийн хууль тогтоомжоос илүү хязгаарлалт үүсгэхээр байна. Тухайлбал, байгалийн нөөц газарт оршиж байгаа хамгаалалтын бүсийн ойд төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглохоор тусгасан бол Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлд 1/ энэ хуулийн 11,15,16 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа, 2/ уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх, 3/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих; 4/ батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах; 5/ биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засаж тохижуулах зэрэг үйл ажиллагааг явуулж болохоор заасантай зөрчилдөхөөр байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоо, нийцлийг хангах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн ойн дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан тухайн газар нутгийн дэглэмтэй нийцүүлэх нь зүйтэй.

Түүнчлэн хамгаалалтын бүсийн ойд хуульд заасан үндэслэл журмын дагуу экологийн боловсрол, танин мэдэхүй, зөөлөн хэлбэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрэгжүүлж болохоор тусгасан боловч нэр томьёо ойлголтын хувьд зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал гэсэн ойлголт нь тодорхойгүй бөгөөд Аялал жуулчлалын тухай хуульд энэхүү нэр томьёог мөн тайлбарлаагүй байна. Иймд “Soft tourism” гэсэн нэр томьёог утгачлан орчуулахдаа Аялал жуулчлалын тухай хуультай уялдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмыг баримтлан нэр томьёоны тайлбарыг хийх нь зүйтэй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж ангилсан байдаг. Тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 -т ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох бүрэн эрхийг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар хуульчилсан байна.

Тус хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийхийг хуульчилсан байдаг. Гэсэн хэдий ч тусгай хамгаалалттай газрын ой болон хамгаалалтын бүсийн ойг тайлбарлан зохицуулсан хууль байхгүй байна.

3.2.5 Хуулийн төслийн 19 дүгээр зүйл

19.1.Дараах газарт иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр ой, модыг тарьж ургуулж, үр шимийг хүртэж болно:

19.1.1.Монгол Улсын иргэн өмчлөлийн газартаа;

19.1.2.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа;

19.1.3.улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт.

19.2.Монгол Улсын иргэн өмчлөлийн газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, модыг өмчилж болно.

19.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, модыг эзэмшиж ашиглаж болно.

Тус заалтууд нь иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор ойжуулалт, мод тарьж ургуулах үйл ажиллагааг дэмжих зорилготой бөгөөд төрийн өмч давамгайлсан ойн салбарт хувийн оролцоог тодорхой хэмжээнд зөвшөөрсөн зохицуулалт гэж үзэж болно. Энэ нь ойн нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх бодлоготой нийцэж байгаа ч, эзэмшлийн эрхийн ялгаа болон хэрэгжилтийн хүрээнд тодорхой сул тал агуулж байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2-т иргэн өмчлөлийн газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, модыг өмчлөх эрхтэй гэж заасан нь өмчийн эрхийг баталгаажуулж, урт хугацааны хөрөнгө оруулалтын сонирхол бий болгоно. Энэ нь иргэдийг мод тарих, арчлах, хамгаалахад илүү идэвхтэй оролцуулах эдийн засгийн хөшүүрэг болж өгдөг. Харин 19 дүгээр зүйлийн 19.3-т иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа тарьж ургуулсан ой, модыг эзэмшиж ашиглах эрх олгосон нь газар өмчлөх эрхгүй субъектүүдийг ч ойжуулалтад оролцуулах боломжийг нээж байна.

Гэсэн хэдий ч эдгээр заалтын сул тал нь өмчлөл, эзэмшлийн эрхийн ялгаа практикт маргаан үүсгэж болзошгүй билээ. Тухайлбал иргэн өмчлөлийн газартаа тарьсан ой, модоо өмчилж болох боловч хуулийн этгээд зөвхөн эзэмшиж ашиглах эрхтэй гэж ялгасан нь эрх зүйн хувьд ялгаатай байдлыг бий болгох магадлалтай. Мөн "үр шимийг хүртэж болно", "эзэмшиж ашиглаж болно" гэх ойлголтуудын хүрээ тодорхой бус байж болох талтай. Тухайлбал модыг огтлох, худалдах, шилжүүлэх, барьцаалах зэрэг эрх хэр хэмжээнд хамаарах нь нарийвчилсан зохицуулалт шаарддаг. Хэрэв энэ нь тодорхойгүй байвал практикт төрийн байгууллага болон хувийн этгээдийн хооронд маргаан үүсэх магадлалтай.

Нөгөө талаас, ойн менежментийн төлөвлөгөөнд туссан газарт хувийн этгээд ойжуулалт хийхийг зөвшөөрсөн нь давуу тал боловч газрын ашиглалт, эзэмшлийн асуудалтай давхцах эрсдэлтэй. Хяналт сул байвал нийтийн зориулалттай газар дээр хувийн ашиг сонирхол давамгайлах, эсвэл байгалийн ойг "таримал ой" нэрээр ашиглах зөрчил гарч болзошгүй. Иймээс дүгнэж хэлбэл, эдгээр заалт нь хувийн хэвшил, иргэдийн оролцоотой ойжуулалтыг дэмжих, ойг нөхөн сэргээхэд эдийн засгийн хөшүүрэг бий болгосон давуу талтай боловч өмчлөл ба эзэмшлийн эрхийн ялгаа, эрхийн хүрээний тодорхой бус байдал, урт хугацааны хөрөнгө оруулалтын баталгааны асуудлаас шалтгаалан хэрэгжилтийн түвшинд маргаан үүсгэх эрсдэлтэй зохицуулалт гэж үзэж болно.

3.2.6 Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг

18.2.Хушин ойд иргэн, хуулийн этгээдээс дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно:

18.2.1.механик аргаар самар бэлтгэх;

18.2.2.байгалийн сэргэн ургалтыг устгах;

18.2.3.хөрс, үндэс гэмтээх;

18.2.4.зөвшөөрөлгүй ашиглах.

Манай улсад дэлхийн Сибирь хуш /*Pinus sibirica* Du Tour/ модны нөөцийн 1.8 хувь нь ургах бөгөөд Монгол орны хушин ойн сангийн нийт талбай нь 612,9 мянган га, нөөц нь 111,2 сая шооометр, ойн нөөцийн 8,9 хувийг эзэлдэг. Хушин ой нь Архангай аймгийн 13 суманд, Баян-Өлгий аймгийн 1 суманд, Булган аймгийн 8 суманд, Завхан аймгийн 2 суманд, Өвөрхангай аймгийн 5 суманд, Хөвсгөл аймгийн 14 суманд, Хэнтий аймгийн 6 суманд, Төв аймгийн 4 суманд, Увс аймгийн 3 суманд,

Сэлэнгэ аймгийн 7 суманд буюу нийт 10 аймгийн 63 сум, Улаанбаатар хотын ногоон бүс, 10 улсын тусгай хамгаалалттай газарт тархан ургаж байна.[16]

Хушны самар нь уураг болон тослогийн хамгийн өндөр агууламжтай өндөр илчлэгтэй хүнсний бүтээгдэхүүн бөгөөд антиоксидант шинж чанартай, судас-цусны эргэлтийг дэмжих, цусны бөглөрлийн эсрэг үйлчилгээ зэрэг хүний эрүүл мэндэд эерэг нөлөө ихтэй. Сибирь хушны самрын найрлага (15–16%) уурагтай, (62–67%) тослогтой, бусад бичил элементүүд болон витамины агууламж өндөртэй. Орчин үед самар болон түүнээс гаргаж авсан бүтээгдэхүүнүүд нь спортын болон тусгай зохицуулах үйлчилгээтэй хүнсний нэг болж байгаагаараа онцлог бөгөөд сүүлийн жилүүдэд манай орны экспортын голлох бүтээгдэхүүний нэг болж байна.[17]

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг нь хушин ойд хориглох үйл ажиллагааг тодорхой зааж өгсөн хамгаалалтын шинжтэй зохицуулалт бөгөөд хушин ойн экосистемийг доройтлоос хамгаалах, самрын нөөцийг тогтвортой ашиглах зорилготой байна. Энэхүү зохицуулалт нь байгаль хамгааллын хувьд олон давуу талтай боловч хэрэгжилт болон эрх зүйн тодорхой байдлын хүрээнд зарим сул талтай. Шинэчилсэн найруулгын төслийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтад механик аргаар самар бэлтгэхийг хориглосон нь зүйтэй юм. Практикт хуш модыг саваагаар хүчтэй цохиж самар унагаах нь мөчир хугарах, холтос гэмтэх, ургалт саарах, улмаар мод үхэх хүртэл сөрөг нөлөө үзүүлдэг. Ийм аргыг хориглосноор хушин ойн доройтлыг бууруулах, урт хугацаанд самрын нөөцийг хадгалах нөхцөл бүрдэнэ. Энэ нь тогтвортой ашиглалтын зарчимтай нийцэж байна.

Мөн хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3 дахь заалтад байгалийн сэргэн ургалтыг устгах, хөрс үндэс гэмтээхийг хориглосон нь экосистемийн хамгаалалтыг зөвхөн модоор хязгаарлахгүйгээр хөрс, залуу ургамал, нөхөн төлжилтийн үйл явцыг хамруулсан давуу талтай. Ингэснээр хушин ойн байгалийн нөхөн сэргэх чадварыг хадгалах боломж нэмэгдэнэ. Ялангуяа хөрс, үндэс хамгаалах зохицуулалт нь уулын бүсийн хөрсний элэгдэл, доройтлоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалтад зөвшөөрөлгүй ашиглахыг хориглосон нь ойн нөөцийн ашиглалтыг төрийн хяналтад байлгах, хууль бус самар түүлт, ашиглалтыг бууруулах давуу талтай. Ингэснээр самрын нөөцийн хэмжээнд үндэслэсэн квот, зохицуулалт хэрэгжих боломж бүрддэг. Гэсэн хэдий ч эдгээр зохицуулалтын сул тал нь хэрэгжилтийн хяналт хүндрэлтэй байдагт оршино. Хушин ой ихэвчлэн алслагдсан, уулын бүсэд байрладаг тул механик аргаар самар түүж байгаа эсэх, хөрс үндэс гэмтээсэн эсэхийг бодит нөхцөлд тогтмол хянахад төвөгтэй, практикт хэрэгжихэд хүндрэлтэй байна. Хяналтын байгууллагын хүний нөөц, техник хэрэгсэл хангалтгүй бол хориглолт хэлбэрийн төдийн шинжтэй үлдэх эрсдэлтэй. Мөн “механик арга”, “хөрс, үндэс гэмтээх” гэх ойлголтуудын шалгуур тодорхой бус байвал практикт тайлбарын зөрүү гарч болно. Жишээлбэл ямар төрлийн багаж хэрэгслийг механик арга гэж үзэх, ямар хэмжээнд хөрс эвдэрснийг зөрчилд тооцох зэрэг нь нарийвчилсан зохицуулалт шаарддаг. Түүнчлэн Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй зарчмын хүрээнд хуулийн төсөлд тусгасан дээрх хориглолтыг зөрчсөн үйлдлийг байгаль, нийгмийн хор аюулын хэмжээг харгалзан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд хариуцлагын хамт тусгах өөрчлөлтийг Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулах нь зүйтэй болно.

Нөгөө талаас, хушны самар нь орон нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэр болдог тул хэт хатуу хориглолт нь эдийн засгийн болон нийгмийн сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй. Хэрэв зөвшөөрөл олгох механизм хүндрэлтэй, эсхүл хүртээмжгүй байвал хууль бус ашиглалт нэмэгдэх эрсдэлтэй болно.

---

[16] Ойн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/178 дугаар тушаалын хавсралт, Хушин ойн самрын биологийн ургац тогтоох аргачлал

[17] Ойн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/178 дугаар тушаалын хавсралт, Хушин ойн самрын биологийн ургац тогтоох аргачлал

Иймээс дүгнэж хэлбэл, 18.2 дахь заалт нь хушин ойн экосистем, байгалийн нөхөн төлжилт, самрын нөөцийг хамгаалах чиглэлээр өндөр ач холбогдолтой, урьдчилан сэргийлэх давуу талтай зохицуулалт боловч хэрэгжилтийн хяналт, ойлголтын тодорхой байдал, орон нутгийн иргэдийн ашиг сонирхолтой уялдуулах асуудлаас шалтгаалан практикт хүндрэл үүсгэх сул талтай гэж үзэж болно.

3.3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь агуулгын хувьд болон бичвэрийн хувьд хэл зүй, найруулгын шаардлага хангаж, ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэх, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийг бүхэлд нь шинжлэн судалсан.

Хүснэгт 8. "Ойлгомжтой байдал" шалгуур хангаагүй хэм хэмжээ, санал

Д/д	Ойлгомжтой бус хэм хэмжээ	Тайлбар	Санал
1.	7.1.Ойн нөөц, экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн бүсийг дор дурдсанаар ангилна: 7.1.1.хамгаалалтын бүсийн ой; 7.1.2.ашиглалтын бүсийн ой; 7.1.3.тусгай зориулалтын ой.	Ойн нөөц, экологи, нийгэм эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн бүсийг хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой, тусгай зориулалтын ой гэж ангилахдаа илүү тодорхой дэлгэрэнгүй зохицуулах нь зүйтэй байна.	Жишээ нь тусгай зориулалтын ой болон тусгай хамгаалалттай газрын ойн ялгааг нэр томьёо тайлбарлах хэсэгт оруулах нь зүйтэй.
2.	10.3.6.экологийн боловсрол, танин мэдэхүй, зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал	Зөөлөн хэлбэрийн аялал жуулчлалд юу юу хамаарахыг тодорхойлох шаардлагатай.	Зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал гэдгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу тухайн зүйлийн доор нэр томьёоны тайлбар оруулах
3.	31.2.Ойжуулалтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ: 31.2.1.бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах, агро ойг хөгжүүлэх; 31.2.2.баянбүрд, хөв цөөрөм, усан сан, ус намгархаг газрыг хамгаалах; 31.2.3.цөлжилт, хөрсний доройтол, элсний нүүлтээс хамгаалах; 31.2.4.төрөл бүрийн зориулалтаар хамгаалалтын ойн зурвас байгуулах;	Ойжуулалтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ гэсэн хэсгийн найруулгыг засах	Дараах үйл ажиллагааг ойлгоно гэж засах боломжтой.

	31.2.5.гол горхи, булаг шанд, хөв цөөрөм хамгаалах; 31.2.6.жимс, жимсгэнийн цэцэрлэг.		
4.	Долоодугаар бүлэг ойг хамгаалах, нөхөн сэргээхэд хүн, хуулийн этгээдийн оролцоо	Бүлгийн дугаарлалт, бүтэц бүхэлдээ ойлгомжгүй.	Хуулийн зүйл заалтын дугаарлалыг засах шаардлагатай.
5.	51.1.Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, орлогын хуваарилалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор Нүүрстөрөгчийн сантай байж болно.	Нүүрстөрөгчийн сантай байж болохоор зохицуулсан нь хаана, ямар байгууллагын дэргэд, хэдэн удаа байгуулах талаар тодорхой болгох шаардлагатай.	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд санг байгуулах талаар тусгах боломжтой.

Түүнчлэн, энэхүү "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад хуулийн төслийг нийцүүлж боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгаж үзье.

Хүснэгт 9. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Ойн тухай хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.Хуулийн төслийн гарчиг; 28.1.2.Хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.Зүйлийн доторх хэсэг; 28.1.4.Хэсгийн доторх заалт; 28.1.5.Заалтын доторх дэд заалт; 28.1.6. Шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан
Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх	
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Хуулийн төсөлд зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудал судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5.Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2. Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.4. Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан бол "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу судалж үнэлгээ хийдэг. Тухайн төслөөр зохицуулж буй харилцаанд өөрчлөлт оруулсан эсвэл шинээр оруулсан зарчмын шинжтэй зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх хүрээнд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтаас сонгон авч судаллаа.

3.4.1 Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

24.3.Сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах шалгуурыг хангасан байна:

24.3.1.техникийн болон мэргэжлийн чадавх;
24.3.2.байгаль орчны менежментийн туршлага;
24.3.3.санхүүгийн чадавх;
24.3.4.нөхөн сэргээлтийн баталгаа;
24.3.5.орон нутгийн оролцоо, ашиг хүртээмжийн санал;
24.3.6.мэдээллийн ил тод байдал, тайлагналын чадавх.

Шинэчилсэн найруулгын 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг нь ой ашиглах, ойн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг сонгон шалгаруулахдаа зөвхөн эдийн засгийн ашиг сонирхлоор бус, техник, байгаль орчин, нийгмийн хариуцлагын шалгуураар үнэлэх зохицуулалт бөгөөд орчин үеийн тогтвортой менежментийн зарчимтай нийцсэн гэж үзэж болно. Техникийн болон мэргэжлийн чадавх, санхүүгийн боломж, нөхөн сэргээлтийн баталгаа зэрэг шаардлага нь ойн нөөцийг мэргэжлийн түвшинд, хариуцлагатай ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэснээр зөвхөн ашиг олох зорилготой, богино хугацааны сонирхолтой этгээдүүдээс сэргийлэх боломжтой.

Техникийн болон мэргэжлийн чадавх, байгаль орчны менежментийн туршлага,санхүүгийн чадавх зэрэг шаардлагууд нь гэрээний хугацаанд ойн нөөцийг зохистой ашиглах, тогтвортой менежмент хэрэгжүүлэх бодит боломжийг шалгах обьектив шинжтэй сонгон шалгаруулалтын үндсэн шалгуур бөгөөд эдгээр нь захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд өрсөлдөөний тэгш нөхцөлийг хангах зорилготой байна. Нөхөн сэргээлтийн баталгаа болон орон нутгийн оролцоо, ашиг хүртээмжийн санал зэрэг нь зөвхөн эдийн засгийн чадавхаас гадна байгаль орчны хамгаалал, нийгмийн хариуцлагын элементүүдийг тусгасан бөгөөд энэ нь орчин үеийн байгаль орчны эрх зүйн урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх зарчимтай нийцэж байна.

Мөн мэдээллийн ил тод байдал, тайлагналын чадавхыг шалгуурт оруулсан нь гэрээний хэрэгжилтийн явцад хяналт, хариуцлагын тогтолцоог хангах, захиргааны хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд энэ нь олон нийтийн хяналт, ил тод байдлын зарчимтай нийцсэн зохицуулалт байна.

Иймд ойн модны нөөцийг Монгол Улсын хуулийн этгээдэд төсөл сонгон шалгаруулах замаар сумын ойн менежментийн төлөвлөгөөний дагуу 10 жилийн хугацаатай гэрээгээр ашиглуулахад төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид тавьсан шаардлагууд нь шаардлагатай зүйлс байх тул хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангаж байна.

3.4.2. Хуулийн төслийн 20 дугаар зүйл

20.2.7.ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах;

Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журмын 1.1-д энэхүү журмын зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангах талаар хүлээх үүрэг, хариуцлага, үүнтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Түймрээс урьдчилан сэргийлэх талаар зохицуулсан байна. 4 дүгээр хавсралтад түймрийг унтраах ажилд оролцож байгаа иргэдийн хувийн хангамжид байх зүйлс болон түймрийг унтраах ажилд оролцож байгаа иргэдийн заавал эзэмшсэн байх арга техник, түймэр унтраах багаж хэрэгслийг ажиллуулах дадлага, чадвар, түймэр унтраах арга, техник болон хөдөлмөр аюулгүйн үйл ажиллагаанд суралцсан байх, түймэр унтраах үед түлэгдэж, гэмтсэн хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвар зэргийг дурдсан байдаг. Гэвч нийт иргэдийн тодорхой хувь нь уг мэдлэгийг эзэмших боломж, нөхцөлгүй байдаг. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт иргэн ойг хамгаалахдаа дараах үүргийг хүлээнэ гэзд ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах гэж иргэний эрх, үүрэг оруулсан нь нэгдүгээрт хуулийн зүйл заалтын дугаарлалт, логикийн хувьд буруу, Хоёрдугаарт энэ үүрэг болгосон заалт нь төрөөс зайлшгүй иргэдэд мэдлэг боловсрол олгож байх олж авах анхан шатны мэдлэг байх тул эдгээр иргэдийг төр өөрөө сургалтад хамруулж, мэдлэг олгох шаардлагатай тул иргэний эрх, үүрэгт оруулсан нь хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангахгүй байна.

3.4.3. Хуулийн төслийн 46 дугаар зүйл

46.2.Давуу эрх олгохдоо дараах шалгуурыг баримтална:

46.2.1.тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх;
46.2.2.хууль ёсны бүртгэлтэй байх;
46.2.3.сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай байх;
46.2.4.байгаль орчны зөрчилгүй, эсхүл зөрчлөө арилгасан байх.

Ой бүхий нутгийн иргэд, нөхөрлөл, малчин, өрхийн анхдагч холбоо, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлд дараах үйл ажиллагаанд давуу эрх олгоно гэж дээрх шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан байна. Тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх, хууль ёсны бүртгэлтэй байх, сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай байх, байгаль орчны зөрчилгүй, эсхүл зөрчлөө арилгасан байх гэж тусгасан нь тухайн этгээд хүлээн зөвшөөрч болохгүй шалгуур үзүүлэлтүүд биш хэцүү нөхцөл гэж үзэхээргүй байх тул хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Учир нь тухайн этгээдийг тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх шаардлага нь орон нутгийн харьяалал, бодит холбоог тогтоох замаар давуу эрхийг зорилтот бүлэгт чиглүүлэх үндэслэл болж байгаа бөгөөд энэ нь эрх зүйн хүрээнд үндэслэлтэй байна. Хууль ёсны бүртгэлтэй байх шаардлага нь тухайн этгээдийн эрх зүйн чадамж, хариуцлага хүлээх боломжийг баталгаажуулж байгаа тул захиргааны эрх зүйн нийтлэг шаардлагад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдөх шалгуур юм. Сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай байх шаардлага нь тухайн этгээдийн бодит гүйцэтгэлийн боломж, техник болон зохион байгуулалтын нөөцөд тулгуурлан сонгон шалгаруулалт хийх зорилготой боловч энэ шалгуур нь үнэлгээний тодорхой аргачлалгүй тохиолдолд захиргааны байгууллагын үзэмжийн хүрээг өргөтгөх, улмаар тэгш байдал, ил тод байдлын зарчимд нөлөөлөх эрсдэлтэй тул хэрэгжилтийн шатанд тодорхой шалгуур үзүүлэлтээр нарийвчлан хэмжигдэх байдлаар зохицуулагдах шаардлагатай байна. Байгаль орчны зөрчилгүй байх, эсхүл зөрчлөө арилгасан байх шаардлага нь байгаль хамгааллын тухай хууль тогтоомжийг мөрдүүлэх, хариуцлагатай оролцоог хангах зорилготой бөгөөд урьдчилан сэргийлэх шинжтэй хууль зүйн үндэслэлтэй шалгуурт тооцогдоно. Дээрх шалгуурууд нь ойн нөөцийн ашиглалтын давуу эрхийг хязгаарлагдмал хүрээнд зорилтот бүлэгт олгох бодлогын шинжтэй, эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой нөхцөлүүдийг тогтоосон байна. Нэмэлтээр хэрэгжилтийн явцад шалгуурын тодорхой байдал, хэмжигдэх шинж, ил тод байдлыг хангах замаар тэгш эрхийн зарчимтай уялдуулах шаардлагатай байна.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах холбоог сайжруулахад дөхөм үзүүлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийе.

Хүснэгт 10. Улсын Их Хурлын бүрэн эрх /Нэмэгдсэн чиг үүрэг/

Улсын Их Хурлын бүрэн эрх /Нэмэгдсэн чиг үүрэг/		
1.	35.1.1 Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахтай холбоотой хууль тогтоомж, ойн салбарын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг батлах төрийн бодлогыг батлах,	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д буй харилцааг илүү дэлгэрэнгүй болгон тогтвортой ашиглах болгон оновчилж мөн тус ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахтай холбоотой хууль тогтоомж, ойн салбарын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг батлах төрийн бодлогыг батлах эрхийг тусгажээ.
2.	35.1.2 Ойн болон ой хээрийн түймрийн талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг тодорхойлох	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ойн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 болон 11.1.3-т заасныг хасч уг зохицуулалтыг шинээр оруулан УИХ-д эрх олгожээ.
Засгийн газрын бүрэн эрх		
1.	36.1.1 Улсын ойн менежментийн төлөвлөгөөг батлах;	Одоогийн мөрдөгдөж буй Ойн тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой заалтуудыг бүгдийг нь хасч уг 2 заалтыг оруулж өгсөн. Улсын ойн менежментийн төлөвлөгөөг батлах эрхийг Засгийн газарт олгохоор тусгажээ.
2.	36.1.2 Аймаг, нийслэлийн ойн асуудал хариуцсан нэгж буюу ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, сум, сум дундын ойн ангийн бүтэц, байршлыг тогтоох;	Шинээр оруулсан заалт бөгөөд Засгийн газар нь аймаг, нийслэлийн ойн асуудал хариуцсан нэгж буюу ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, сум, сум дундын ойн ангийн бүтэц байршлыг тогтоох эрхийг олгосон байна.

Хүснэгт 11. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал

	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
2.	Хуулийн төслийн хууль тогтоомж гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёонд нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4.	Хуулийн зүйл, хэсэг, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Судалгаагаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалттай нийцэхгүй.
5.	Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгад оруулж буй өөрчлөлтүүдтэй холбогдуулан Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, Ойжуулалтын сан болон Нүүрстөрөгчийн сантай холбоотой зохицуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар зохицуулалтыг нэмж тусгах, татварын болон бусад дэмжлэг үзүүлж болохоор заасан боловч татварын хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусгаагүй.
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зүйл байхгүй байна.
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар, төлбөр, хураамж шинээр тогтоосон зүйл байхгүй байна.
11.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Төсөлд орон нутгийн иргэдэд давуу байдал олгохоор тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2 -т заасан Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэнтэй зөрчилдөж байна.

12.	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
13.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
14.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслийн 18.1.1, 45.2, 7 дугаар бүлэгт зөвшөөрөл олгох, квот тогтоохтой холбоотой харилцааг зохицуулсан ба эдгээр заалтууд нь авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалтууд байх магадлалтай.
15.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хориглосон, хязгаарласан зохицуулалттай холбоотойгоор Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд үйлдэл, хариуцлагыг тусгахтай холбоотой өөрчлөлтийн төслийг боловсруулаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1.Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн[18] Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна." гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн" гэж тус тус заасан. Алсын хараа-2050[19] Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго 6-д "Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна" гэж, уг бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.1.3-т "Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ." гэж, 6.2.3-т "...ойн агро парк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна." гэж, 6.2.4-т "Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ" гэж тус тус заасан байна.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газраас ойн хомсдол, доройтлыг бууруулан, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх зорилгоор нийт 1.5 тэрбум мод, сөөг тарьж, ойг нөхөн сэргээх болон таримал ойн талбайг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ нь ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэхэд шинээр ой бий болгох, мод, сөөгийг тарималжуулах, ойн санд бүртгэх, өмчийн харилцааг нь тодорхой болгох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ байгааг харуулж байна.

Хуулийн төслийн хүрээнд төрөөс ойн талаар баримтлах зарчмыг тусгайлсан бүлэг, зүйл болгон оруулж ирсэн нь бодлогын тодорхой байдлыг хангах ач холбогдолтой боловч агуулгын хувьд хуулийн зорилго, зарчим хоёрын зааг ялгааг бүрэн гаргаагүй, нэр томьёоны давхардалтай байна. Мөн тус зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалтыг төсөлд тусгаагүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой дараах гол асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй:

Хушин ойн менежментийн зохицуулалт: Хушин ойг ердийн ашиглалтын ойгоос тусад нь авч үзэж, самрын нөөцөд квот тогтоох замаар хамгаалалтын тусгай горим тогтоосон нь дэвшилттэй алхам юм. Гэвч уг заалтууд нь менежментийн харилцааг иж бүрэн зохицуулахад хэт ерөнхий, тунхаг төдий байгаа тул ашиглалтын дараах нөхөн сэргээлт, тээвэрлэлт, боловсруулалтын шатанд гарах нарийвчилсан харилцааг журамлах шаардлагатай байна. Түүнчлэн хушны самар болон бусад ойг ашиглахтай холбоотой зөвшөөрөл олголтын зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах, харин гэрчилгээ, гэрээ, зөвшөөрлийн загварыг холбогдох сайдын тушаалаар батлах нь зөвшөөрлийн харилцааг хуулиар зохицуулах, авлига ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх, хуулийн тогтвортой хэрэгжих нөхцөл боломжийг хангах ач холбогдолтой байна.

Нэр томьёоны тодорхойгүй байдлын хүрээнд жишээлбэл (Soft Tourism): Хамгаалалтын бүсийн ойд "зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал" (soft tourism) явуулна гэж заасан нь Аялал жуулчлалын тухай хуультай уялдаагүй, ойлгомжгүй байна. Энэхүү нэр томьёог утгачлан орчуулахдаа хуульд нийцүүлэн тайлбарлах шаардлагатай ба эс бөгөөс практикт дур мэдэн тайлбарлах, үүнээс үүдэлтэй хууль зүйн хийдэл гарах хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах эрсдэлтэй байна.

[18] Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн
[19] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Ойжуулалтын сан болон нүүрстөрөгчийн сангийн талаарх зохицуулалтуудыг Засгийн газрын газрын тусгай сангийн тухай хуультай уялдуулан илүү боловсронгуй болгож, хийдэл үүсгэхгүй байх зүйтэй. Ингэхдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар дээрх 2 сангийн эх үүсвэр, зарцуулалт, түүний механизм, хяналт, тайлагналт болон ажлын албатай байх эсэхийг шийдвэрлэх нь ач холбогдолтой байна.

Хуулийн төсөлд ойжуулалт, ойн ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлтийг татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр тусгасан байна. Гэвч эдгээр дэмжлэг олгохтой холбоотой зохицуулалт нь тунхгийн шинжтэй хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байгааг анхаарах нь зүйтэй байна. Хуулийн төслийг дагалдуулан татварын хөнгөлөлт эдлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг татварын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хэлбэрээр тусгаагүй нь хуулийн төслийн дээрх зохицуулалт ямар үр дүнгүй болохоор байна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, төслийн үзэл баримтлал нь ойн салбарт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, экосистемийн үйлчилгээг үнэлэх бодлогын эерэг өөрчлөлтийг агуулж байгаа боловч хэрэгжилтийн түвшний тодорхойгүй байдал, нэр томьёоны зөрүү, урт хугацааны хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгаа дутмаг байгаа нь хууль хэрэгжих явцад эрсдэл дагуулж болзошгүй байна. Иймд эдгээр асуудлыг салбарын бусад хууль тогтоомжтой уялдуулан дахин нягталж, дэлгэрэнгүй зохицуулах шаардлагатай байна.

Үүнээс нэгтгэн дүгнэхэд одоогийн Ойн тухай хуулиас илүү системтэй, зах зээлийн, эдийн засгийн болон тогтвортой хөгжлийн зарчмыг тусгасан, олон улсын сайн туршлагад ойртсон зохицуулалтыг хийхийн оролдсон боловч практикт хэрэгжихэд хүндрэлтэй тунхгийн шинжтэй заалтууд хэвээр байна. Хуулийн төслийг дагалдуулан бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, үнэлгээ хийлгэхээр ирүүлээгүй нь хууль зүйн нэгдмэл бодлого, хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах, хууль зүйн үр дагавар үүсгэсэн зохицуулалтыг амилуулах зэрэгт хүндрэл учрах бөгөөд Хууль тогтоомжийн хуулийн холбогдох зохицуулалттай нийцэхгүй байна.

Хуулийн хэрэгжилтийн үндэс нь хяналт, ил тод байдал, орон нутгийн чадавх, цахим системийн бодит нэвтрэлт, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрээс шууд хамаарах тул эдгээрийг давхар шийдвэрлэхгүй бол практикт бүрэн хэрэгжихэд хүндрэлтэй хэвээр байх магадлалтай байна.

4.2. Зөвлөмж

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээ, түүний нэгдсэн дүгнэлтээс гадна эцэслэн боловсруулах явцад боловсронгуй болгох, сайжруулах боломжтой, асуудлыг илүү тодорхой болгох, анхаарах шаардлагатай дараах асуудлуудыг тодорхойлж байна. Үүнд:

- Ойн нөөц болон түүний дагалт баялаг тухайлбал, хушны самрыг ашиглахтай холбоотой зөвшөөрөл олголтын зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуультай уялдуулан хуулийн төсөлд нарийвчлан тусгах. Тухайлбал, тухайн зөвшөөрлийг хэн, ямар баримт бичгийг үндэслэн, хэдий хугацаанд, хэрхэн яаж олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах нөхцөл, үйл ажиллагааны журмыг Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах. Харин гэрчилгээ, гэрээ, зөвшөөрлийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлах;
- Хуулийн төсөлд тусгасан нэр томьёоны тодорхойгүй байдлыг арилгах хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэр томьёотой нийцүүлэх, зөвхөн тухайн хуульд хэрэглэгдэх нэр томьёог тайлбар байдлаар оруулах зэрэг. Тухайлбал, хуулийн төсөлд хамгаалалтын бүсийн ойд "зөөлөн хэлбэрийн аялал жуулчлал" (soft tourism) явуулна гэж тусгасныг Аялал жуулчлалын тухай хуультай уялдуулах, нэр томьёог утгачлан орчуулахдаа хуульд нийцүүлэн тайлбарлах шаардлагатай байна.
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар дээрх ойжуулалтын сан, нүүрстөрөгчийн сангийн эх үүсвэр, зарцуулалт, түүний механизм, хяналт, тайлагналт болон ажлын албатай байх эсэхийг шийдвэрлэх;

- Ойг нөхөн сэргээх, тарималжуулахад төрөөс дэмжлэг олгохтой холбоотой зохицуулалт нь тунхгийн шинжтэй хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байх тул хуулийн төслийг дагалдуулан татварын хөнгөлөлт эдлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг татварын хууль тогтоомжид тусгах;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, экосистемийн үйлчилгээг үнэлэх бодлогын эерэг өөрчлөлтийг агуулж байгаа боловч хэрэгжилтийн түвшний тодорхойгүй байдал, нэр томьёоны зөрүү, урт хугацааны хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгаа дутмаг байгаа нь хууль хэрэгжих явцад эрсдэл дагуулж болзошгүй байна. Иймд эдгээр асуудлыг салбарын бусад хууль тогтоомжтой уялдуулан дахин нягталж, дэлгэрэнгүй зохицуулах;
- Хуулийн төслийг практикт бүрэн хэрэгжүүлэх хүрээнд хяналт, ил тод байдал, орон нутгийн чадавх, цахим системийн бодит нэвтрэлт, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг цогц байдлаар шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгах;
- Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалтын уялдааг хангаж, хоорондын зөрчлийг арилгах, бусад хууль тогтоомжтой уялдуулах гэх зэргээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу хуулийн төслийг сайжруулан боловсруулах нь зүйтэй байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;
2. Агентлагийн тухай хууль, 2004 он;
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 он;
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он;
5. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 2020 он;
6. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он;
7. Ойн тухай хууль, 2012 он;
8. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
9. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 52, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг батлах тухай, 2020 он;
10. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 488 "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батлах тухай", 2010 он;
11. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 21, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай", 2024 он;
12. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Дугаар 350, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2021 он;
13. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Дугаар 59, Аргачлал батлах тухай
14. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 106, "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай", 2021 он;
15. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоолын хавсралт, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ;
16. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл;
17. Ойн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/178 дугаар тушаалын хавсралт, Хушин ойн самрын биологийн ургац тогтоох аргачлал.

Ном, сурах бичиг

1. Т.Сэнгэдорж, Экологийн эрх зүйн гарын авлага, 2007 он.
2. Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)ийн "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл", Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, /Гарын авлага/, 2016 он;
3. Азийн хөгжлийн банк, TT-9899, Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2:Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, төгсгөлийн тайлан, 2023 он;
4. TA-9899 MOH: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр (сум дундын) ойн ангийн үнэлгээ Тайлангийн төсөл, 2023 он;
5. TT-9899 MOH: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх заавар, 2023 он;
6. TA-9899: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр зах зээл ба өртгийн сүлжээний шинжилгээ, 2023 он;
7. TA-9899 MOH: Ойн Салбарын Хөгжлийн Хөтөлбөр: 2-р боть: Салбарын шинэчлэлийн стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөө Хавсралт А3: Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замын зураг, 2023 он;
8. TA-9899 MOH: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр /Ойн нөхөрлөлүүдэд хийсэн үнэлгээ/, 2023 он;
9. YCX, Байгаль орчин-эдийн засгийн данс: Ойн нөөцийн данс-2023, 2024 он;
10. БОАЖЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Монгол Улсын ойн сан /албан хэрэгцээнд/, 2020 он;
11. Б.Удвал, Хушны самрыг зүй зохистой түүж бэлтгэх, ашиглах гарын авлага, 2020 он;

Эрдэм шинжилгээний бүтээл

1. Ойн тухай хууль: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 2025 он.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах нэр бүхий 22 хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тодорхойлох тандан судалгаа, 2025 он.
3. Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, №3(74), Улаанбаатар хот, 2005 он.

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. FAO, Global Forest Resources Assessment: Terms and Definitions, 2020, https://www.fao.org/4/ap862e/ap862e00.pdf, (Сүүлд үзсэн: 2026.05.07).
2. Law No. 29/2004/QH11 of December 03rd, 2004, On Forest Protection and Development.
3. Jean-Daniel Bontemps, Olivier Bouriaud, “Take five: about the beat and the bar of annual and 5-year periodic national forest inventories”, Annals of Forest Science, 2024.

Цахим эх сурвалж

1. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан, https://finance.eic.mn/implement?y=2024&a
2. ЕХ-ны 2030 оны Ойн Стратеги, https://environment.ec.europa.eu/strategy/foreststrategy_en
3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралт, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч, https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141010887611&showType=1
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн - www.1212.mn
5. Судалгааны хүрээлэнгийн цахим хуудас: jtrii.mn